



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 01 сарын 28 өдөр

Дугаар А/33

Чингис хот

Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт
шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29-дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь заалт, Улсын Онцгой комиссын 2020 оны 01 дүгээр хурлын тэмдэглэл, Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/19 тоот албан даалгавар, Аймгийн онцгой комиссын 2020 оны 02 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бүс нутгийн болон хил залгаа улс орнуудад амьсгалын замын коронавирус /coronavirus/-ын халдвар тархаж, Монгол улс нь энэхүү вирус тархах “өндөр эрсдэлтэй” ангилалд хамрагдсан, аймгийн хэмжээнд томуу, томуу төст өвчний эзлэх хувь 16.2 промильд хүрсэн тул аймгийн Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг, Зооноз өвчин судлалын төв, сум дундын эмнэлгүүд, сумын эрүүл мэндийн төв, өрхийн эмнэлгүүдийг 1 дүгээр сарын 28-ны өдрөөс 3 дугаар сарын 02-ны өдрийг хүртэл өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсүгэй.

2. Өвчлөлийн байдалд хяналт тавьж, эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангах, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг бүрэн хангаж ажиллахыг Эрүүл мэндийн газар /Ц.Гэрэлмаа/-т, Худалдаа, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага, аж ахуйн нэгжүүдэд урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулж, мэргэжлийн заавар зөвлөмж өгч ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар /Б.Сүнгээ/-т, Цагдаагийн газар /цагдаагийн хурандаа Б.Батсайхан/-т, Иргэдэд үнэн зөв мэдээлэлийг хүртээмжтэй түргэн шуурхай хүргэж ажиллахыг холбогдох байгууллагуудын удирдлага, орон нутгийн хэвлэл мэдээлэлийн байгууллагын дарга нарт, Олон нийтийг хамарсан төрөл бүрийн арга хэмжээг харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд тогтоосон хугацаагаар хязгаарлахыг сумын Засаг дарга нарт, Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан үүргийн биелэлтэд хяналт тавьж, хэрэгжилтийн хангаж ажиллахыг Онцгой байдлын газар /дэд хурандаа Н.Чанцал/-т тус тус үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Г.Хэрлэнчулуун/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Н.ГАНБЯМБА



• 231010202



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 01 сарын 28 өдөр

Дугаар А/33


Чингис хот

Өндөржүүлсэн бэлэн байдал зарлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь заалт, Улсын Онцгой комиссын 2020 оны 01 дүгээр хурлын тэмдэглэл, Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/19 тоот албан даалгавар, Аймгийн онцгой комиссын 2020 оны 02 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Олон нийтийг хамруулах төрөл бүрийн арга хэмжээг харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд түр хугацаагаар хязгаарлахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай
2. Үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа газруудад урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулж, мэргэжлийн заавар зөвлөмж өгч ажиллахыг аймгийн Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Эрүүл мэндийн газар болон сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.
3. Иргэдэд үнэн зөв мэдээлэлийг хүртээмжтэй түргэн шуурхай хүргэж ажиллахыг холбогдох байгууллагын удирдлагууд, орон нутгийн хэвлэл мэдээлэлийн байгууллагуудын дарга нарт үүрэг болгосугай.
4. Өвчлөлийн байдалд хяналт тавьж, эмнэлэгийн тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангах, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг бүрэн хангаж ажиллахыг аймгийн Эрүүл мэндийн газар, Мэргэжлийн хяналтын газарт үүрэг болгосугай.
5. Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан үүргийн биелэлтэд хяналт тавьж хэрэгжилтийн хангаж ажиллахыг Онцгой байдлын газрын дарга /Н.Чанцал/-д үүрэг болгосугай.
6. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Г.Хэрлэнчулуун/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

231010184